

Сайн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө амь нас аварна!! 2024 оны 6 сар



1-р зураг. ЖЭ 516 нислэгт гарсан гал, мөргөлдсөн онгоцнуудын байршил

2024 оны 1-р сарын 2-нд 367 зорчигч, нислэгийн багийн 12 гишүүнтэй Жапан Эйрлайнс (ЖЭ)-ын 516 дугаар нислэг Японы Токио хотын Ханеда нисэх онгоцны буудалд газардаж байхдаа хөөрөх зурвас дээр эргийн хамгаалалтын хөнгөн онгоцтой мөргөлдөж, хоёр онгоц хоёулаа шатсан байна. Ослын улмаас бага оврын онгоцонд сууж явсан багийн зургаан гишүүний тав нь нас барсан. ЖЭ-ын онгоцны зүүн хөдөлгүүр шатаж байсан ч ЖЭ-ын 516 дугаар нислэгт явж байсан 379 хүнийг онгоц газардсанаас хойш 18 минутын дотор нүүлгэн шилжүүлж чадсан байна.

Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөгөө маш сайн мэдэж байсны ачаар том онгоцноос хүмүүсийг аюулгүй нүүлгэн шилжүүлж чадсан. Нисгэгчийн бүхээг, үйлчлэгч нар хоорондоо холбоо тасарсан ч 516 дугаар нислэгээс хүний амь нас эрсдээгүй байна.

Багийнхан ослын гулсуур ашиглахад аюулгүй эсэхийг шалгасан даруйдаа яаралтай арга хэмжээ авч дэлгэсэн. Зорчигчдыг гулсуур руу шуурхай, гэхдээ ээлж дараатайгаар буулгасан. Нисгэгч, үйлчлэгч нар онгоцноос хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг аль болох шуурхай эхлүүлэх бэлтгэлтэй байсан.

Аюулгүй нүүлгэн шилжүүлэхэд нөлөөлсөн өөр нэг хүчин зүйл нь багийнхан зорчигчдыг гар утаснаас бусад бүх зүйлээ орхихыг шаардсан явдал байв. Бусад зүйлсээ авч гарна гэвэл ажиллагаа удааширч, хүний амь нас эрсдэх аюултай. Энэ талаар агаарын тээврийн компани нислэгийн өмнөх аюулгүй ажиллагааны мэдэгдэлд онцлон сануулсан бөгөөд зорчигчид уг зааврыг дагаж мөрдсөн.

Та мэдэх үү?

- Аюултай химийн бодистой харьцдаг, хадгалдаг үйлдвэрүүд онцгой байдлын төлөвлөгөөндөө аюултай материал асгарах, хий алдах тохиолдлыг тусгасан байх ёстой.
- Ихэнх улс орнууд, компаниуд цаг агаарын онцгой үзэгдэл, үер, газар хөдлөлт, цунами зэрэг урьдчилан таамаглах боломжтой байгалийн гамшгийн үед авч хэрэгжүүлэх албан ёсны Онцгой байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байх шаардлагатай. Төлөвлөгөөнд мөн гал түймэр, ажлын талбараас аюулгүй нүүлгэн шилжүүлэх асуудлыг тусгах шаардлагатай.
- Үйлдвэрийн үйл ажиллагаанд гарсан гал түймэр маш хурдан тархдаг. Оффисын өрөөнд ч гэсэн хивс, бусад шатамхай материалууд гал авалцаж, хурдан шатдаг.
- Гал түймрийн нөлөөллийг бууруулах гол хүчин зүйл бол ослын дохиоллын системийг даруй идэвхжүүлэх юм. Дохиоллыг ажиллуулах эсэхдээ эргэлзэж, эсвэл хожимдож ажиллуулснаар нүүлгэн шилжүүлэх, гал унтраах ажиллагааг удаашруулж болзошгүй.
- Зарим дүрэм журамд нүүлгэн шилжүүлэх зам, хоргодох байр, цугларах цэг зэргийг газрын зураг дээр харуулахыг шаарддаг.

Та юу хийх ёстой вэ?

- Нүүлгэн шилжүүлэх зам, хоргодох байр, цугларах цэгийн байршил зэргийг заасан ажлын талбар дахь онцгой байдлын үед нүүлгэн шилжүүлэх журмыг мэддэг байх
- Таны ажиллаж байгаа хэсэгт ослын дохиоллыг хэрхэн, хэзээ идэвхжүүлдгийг мэддэг байх. Хэрэв мэддэггүй бол ахлах ажилтнаасаа асуух.
- Онцгой байдлын сургуулилтад идэвхтэй оролцох. Гарах зам, алхах гадаргуу саадтай, гарцын тэмдэг тэмдэглэгээ байхгүй зэрэг жинхнээсээ онцгой байдал үүссэн үед сөргөөр нөлөөлж болзошгүй асуудлыг тэмдэглэж авах.
- Тогтмол хийгддэг үзлэг шалгалт, талбайн үзлэг хийхдээ ямар онцгой нөхцөл байдал үүсэж болох, уг нөхцөл байдлыг онцгой байдлын нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан эсэхийг бодож үзээрэй.
- Тухайн газрыг нэгэнт орхисон бол "бүгд аюулгүй" гэсэн төлөвт орсныг зарлах хүртэл буцаж орж болохгүй. (2024 оны 4-р сарын Beacon дугаарыг үзнэ үү)

Нүүлгэн шилжүүлэлтийн журмаа мэддэг мөн дагаж мөрддөг байгаарай!